

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой ХК 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/028/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn
Өмнөговь аймаг
2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Аудитын менежер Т.Хонгорзул
Ахлах аудитор Ж.Болормаа

Туслан гүйцэтгэгч:
Гүйцэтгэх захирал

Солид Юнити аудит ХХК
Э.Мөнхтогтох

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	0
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	0
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	0
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	1
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	2
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	0
3.1 Компани түүний үйл ажиллагаа.....	0
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	0
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	0
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	1
3.5 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэл.....	1
4. АУДИТЫН ТАЙЛАН	2
4.1 Ерөнхий зүйл.....	2
4.2 Материаллаг байдал.....	2
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	3
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	3
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	3
4.5.1 Завсрын аудитын талаар.....	3
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	3
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	4
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	5
5.1 Төлбөрийн акт.....	8
5.2 Албан шаардлага	8
5.3 Зөвлөмж	10
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НАБТ	Нүүрс ачиж буулгадаг талбай

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.12 № 295
талай _____ ний № _____ -т

ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.ГҮНЖДАГВА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дансны өглөгийн 31 хувь буюу 5,513.4 сая төгрөгийн үлдэгдэл, дансны болон бусад авлагын 49 хувь буюу 29,641.0 сая төгрөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, ногдол ашгийн өглөгт 2022 оноос хойш хөдөлгөөн ороогүй, харилцагчийн нэр, хэзээ төлөх нь тодорхойгүй хэвээр, уурхайн харуул хамгаалалтын зардлыг олборлосон нүүрсний өртөгт хуримтлуулан бүртгээгүй, нэг удаагийн тэтгэмжийг стандартын дагуу бүртгэж олгоогүй, засвар үйлчилгээний ажилд шууд гэрээ байгуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, СТОУС 9, НББОУС 19 стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны ТОП-20 индекс шинэчлэгдэж, индексийн хоёрдугаарт эрэмбэлэгдэж, тус компанийн зах зээлийн үнэлгээ 1.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

4625020593

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эдийн засгийн зорилтод түвшинд нийт орлогыг 3,458,044.3 сая төгрөг, зардныг 2,019,835.8 сая төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 1,165,127.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 616,003.7 сая төгрөг зарцуулж, 549,159.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудал

Өмнөх оны сүүлийн хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу "Солид Юнити Аудит" ХХК-тай гэрээ байгуулан 2022, 2023 оны санхүүгийн тайланд аудит гүйцэтгүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.СӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	718,428,614,942.77	373,701,070,884.89
1.1.3	Дансны авлага	65,920,588,194.87	47,685,035,980.09
1.1.4	Татвар, шимтгэлийн авлага	438,833,228.20	4,537,003,911.17
1.1.5	Бусад авлага	43,910,793.90	1,005,114,885.92
1.1.6	Бараа материал	35,908,436,551.62	219,319,588,089.11
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	12,958,640,738.01	68,825,671,911.73
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	17,967,142.86
1.1.9	Эргэлтийн хөрөнгийн дүн	833,699,024,449.37	715,091,452,805.78
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,895,059,846.13	26,577,999,980.90
1.2.2	Биет бус хөрөнгө	6,322,801,239.42	6,593,329,434.69
1.2.3	Биологийн хөрөнгө	19,770,000.00	43,707,142.85
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	3,325,464,613.89
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	31,358,326,886.25
1.2.7	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,671,810,543.04	68,333,007,516.07
1.3	ХӨРӨНГИЙН ДҮН	861,370,834,992.41	783,424,460,321.85
2.1.1	Дансны өглөг	7,285,146,072.37	18,074,449,920.88
2.1.2	Цалингийн өглөг	8,083.66	1,096,680,246.66
2.1.3	Татварын өр	282,406,987,651.93	22,573,244,443.95
2.1.4	НДШ-ийн өглөг	-	79,857,499.78
2.1.5	Ногдол ашгийн өглөг	658,515,350.94	658,515,350.94
2.1.6	Урьдчилж орсон орлого	160,739,640,528.70	202,309,176,909.15
2.1.7	Бусад богино хугацаат өр төлбөр	1,353,517,164.38	16,636,153,436.63
2.1.8	Богино хугацаат өр төлбөрийн дүн	452,443,814,851.98	261,428,077,807.99
2.2.1	Нөөц ба өр төлбөр	-	8,218,026,827.94
2.2.2	Хойшлогдсон татварын өр	-	4,451,524,250.96
2.2.3	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	12,669,551,078.90
2.2.4	Нийт өр төлбөрийн дүн	452,443,814,851.98	274,097,628,886.89
2.3.1	Өмч	94,487,644.09	94,487,644.09
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	5,876,231,609.00	5,876,231,609.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	402,956,300,887.34	503,356,112,181.86
2.3.5	Эздийн өмчийн дүн	408,927,020,140.43	509,326,831,434.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	861,370,834,992.41	783,424,460,321.85

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,094,131,211,392.88	1,158,398,002,569.02
2	Борлуулалтын өртөг	216,473,677,251.22	589,030,425,656.49
3	Нийт ашиг	877,657,534,141.66	569,367,576,912.53
4	Түрээсийн орлого		35,536,762.73
5	Хүүний орлого	1,080,208,252.95	4,146,634,873.50
7	Бусад орлого	2,151,531,351.12	2,583,139,636.12
8	Борлуулалт маркетингийн зардал	355,531,258,389.05	4,368,300,610.58
9	Ерөнхий ба удирдлагын зардал	3,835,602,899.21	16,575,572,532.76
10	Санхүүгийн зардал	996,904.44	-
11	Бусад зардал	15,600,305,930.42	2,711,170,054.27
12	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(991,110,540.99)	(3,318,263,996.02)
14	Татварын өмнөх ашиг	504,929,999,081.62	549,159,580,991.25
15	Орлогын татварын зардал	129,070,544,963.08	136,804,310,675.46
16	Тайлант жилийн ашиг	375,859,454,118.54	412,355,270,315.78

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Эздийн өмчийн дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	468,414,309.00	318,384,260,606.89	318,947,162,559.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			8,911,999.99	8,911,999.99
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	468,414,309.00	318,393,172,606.88	318,956,074,559.97
Бусад дэлгэрэнгүй орлого		5,407,817,300.00		5,407,817,300.00
Зарласан ногдол ашиг	-		291,278,501,838.10	291,278,501,838.10
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		375,859,454,118.54	375,859,454,118.54
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	402,956,300,887.34	408,927,020,140.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	17,240,999,821.26	17,240,999,821.26
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	385,715,301,066.08	391,686,020,319.17
Зарласан ногдол ашиг	-	-	294,714,459,200.00	294,714,459,200.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	412,355,270,315.78	412,355,270,315.78
2024 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	503,356,112,181.86	509,326,831,434.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	1,173,768,433,481.55	1,282,218,696,341.70
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,170,865,174,657.83	1,231,077,607,090.20
1.1.2	Буцаан авсан албан татвар		1,875,000,000.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	2,903,258,823.72	49,266,089,251.50
1.2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	588,725,746,145.94	1,337,437,747,557.11
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	11,434,182,175.18	69,593,006,681.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,328,312,315.68	5,273,835,060.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	868,118,931.00	2,614,334,654.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	560,820,547.25	412,755,261.65
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	162,848,901,824.34	2,710,293,436.85
1.2.6	Төлсөн татвар	120,319,620,388.73	525,995,783,572.83
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	106,752,820.00
1.2.8	Бусад зардалд төлсөн мөнгө	289,365,789,963.76	730,730,986,070.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,762,494,179,627.49	2,619,656,443,898.81
2.1.3	Хүлээн авсан хүүгийн орлого	1,080,208,252.95	6,944,385,376.17
2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,916,390,246.00	5,943,910,902.39
2.2.1	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,150,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	3,003,748,498.95	12,888,296,278.56
3.1.2	Төлсөн ногдол ашиг	278,094,537,258.86	287,327,016,429.84
3.1.3	Бусад		4,722,302,173.75
3.2	Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	278,094,537,258.86	292,049,318,603.59
3.3	Гадаад валютын ханшийн зөрүү	3,781,073,259.66	7,904,253,059.26
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,047,373,538,644.96	2,932,498,311,840.22
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	408,542,723,599.41	718,428,614,942.77
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	718,428,614,942.77	373,701,070,884.89

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биетээр/					
	Нүүрс олборлолт	Мянган төг	3,573.3	7,502.3	4,335.5	(3,166.8)
	Нүүрс борлуулалт	Мянган төг	3,117.6	7,502.3	2,714.4	(4,787.9)
	Үүнээс: Экспорт	Мянган төг	2,543.8	6,921.5	2,324.7	(4,596.8)
	Дотоод	Мянган төг	573.8	580.8	389.7	(191.1)
	Хөрс хуулалт	Мянган м3	15,352.8	37,511.7	24,027.6	(13,484.1)
	Нийт уулын цул	Мянган м3	17,848.5	42,870.5	27,613.1	(15,257.4)
2	Нийт борлуулалт /үнийн дүнгээр/					
	Цэвэр борлуулалт	Мянган төг	1,094,131,211.4	3,458,044,311.4	1,158,398,002.6	(2,299,646,308.8)
	Хүүний орлого	Мянган төг	1,080,208.3	8,000,000.0	4,146,634.9	3,853,365.1
	Бусад орлого	Мянган төг	2,151,531.4		2,618,676.40	(2,618,676.4)
3	Нийт зардал	Мянган төг	592,343,854.2	2,019,835,797.6	616,003,732.9	(1,403,832,064.7)
	Үүнээс: а.Үндсэн үйлдвэрлэл	Мянган төг	217,376,687.0	2,001,758,906.9	589,030,425.6	(1,412,728,481.3)
	б. Ерөнхий ба удирдлагын зардал	Мянган төг	359,366,861.3	16,553,508.6	20,943,873.1	4,390,364.5
	в.Үйл ажиллагааны бус зардал	Мянган төг	15,600,305.9	1,523,382.11	6,029,434.2	4,506,052.1
4	Татвар төлөхийн өмнөх ашиг /ТТӨА/	Мянган төг	504,929,999.1	1,446,208,513.7	549,159,581.0	(897,048,932.8)
5	Цэвэр ашиг	Мянган төг	375,859,454.1	1,085,556,385.3	412,355,270.3	(673,201,115.0)
6	Төсөвт төлөх нийт төлбөр	Мянган төг	283,520,905.2	825,290,298.1	525,995,783.6	(299,294,514.5)
	Үүнээс: АМНАТөлбөр	Мянган төг	147,162,887.8	340,159,219.0	114,301,647.0	(225,857,572.0)
	Орлогын албан татвар	Мянган төг	129,070,545.0	360,652,128.0	136,804,310.7	(223,847,817.3)
	Бусад/9 төрөл/	Мянган төг	7,287,472.4	124,478,951.1	274,889,825.9	150,410,874.9
7	Ногдол ашиг хуваарилалт	Мянган төг	263,115,339.2	922,722,927.5	294,714,459.2	(628,008,468.3)
	Үүнээс: Орон нутаг	Мянган төг	134,188,823.0	470,588,693.0	150,304,374.2	(320,284,318.8)
	Бусад ХЭ	Мянган төг	128,926,516.2	452,134,234.5	144,410,085.0	(307,724,149.5)
8	Хөрөнгө оруулалт	Мянган төг	11,359,224.0	86,760,000.0	10,929,250.2	(75,830,749.8)
9	Нийт авлага	Мянган төг	66,403,332.2	-	53,227,154.80	(53,227,154.80)
	Үүнээс: Борлуулалтын авлага	Мянган төг	57,279,955.0	-	47,685,036.0	-
	Татвар шимтгэлийн авлага	Мянган төг	-	-	4,537,003.9	-
	Бусад авлага	Мянган төг	9,123,377.2		1,005,114.9	
10	Нийт өр төлбөр	Мянган төг	452,443,814.9	138,145,450.1	274,097,628.9	314,298,364.8
	Богино хугацаат өр төлбөр	Мянган төг	452,443,814.9	138,145,450.1	261,428,077.8	123,282,627.7
	Урт хугацаат өр төлбөр	Мянган төг	-	-	12,669,551.1	-
11	Төлсөн татвар, хураамж нийт дүн	Мянган төг	283,520,905.2	825,290,298.1	525,995,783.6	(299,294,514.5)
12	Нийт ажиллагсдын тоо	Хүн	286	308	289	(19.0)
13	Нийт цалингийн сан	Мянган төг	13,790,392.4	25,906,833.5	24,727,055.3	(1,179,778.2)
14	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.54	0.58	0.53	(0.05)
15	1 тонн нүүрсний ашиг	төгрөг	120,560.5	144,696.5	151,912.3	7,215.9
16	Ашгийн хувь	хувь	34.4%	31.4%	35.6%	-
17	Хөрс хуулалтын коэффициент	м3/тонн	4.3	5.0	5.5	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн орон нутгийн өмчит Тавантолгой ХК –ийн ордыг анх 1966 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 124 дүгээр тогтоолоор улсын өмч болгож, үйлдвэрийн аргаар ашиглахаар шийдвэрлэн Аж үйлдвэрийн яаманд шилжүүлэн өгч, ил уурхайгаар ашиглаж Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн төв болон ойролцоох сумдын нүүрсний хэрэгцээг хангаж ирсэн ба 1967 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 30 дугаар тогтоолыг үндэслэн бие даасан уурхай болгон байгуулжээ.

БНМАУ-ын Засгийн газрын өмч хувьчлалын 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 42 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчилж 1995 онд орон нутагт шилжүүлсэн байна.

Тавантолгой ХК-ийн орд газар нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун урд зүгт 15 км, Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт боомтоос 270 км зайд байрладаг байна.

Тавантолгой ХК-ийн зорилго нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, дэвшилтэт технологид тулгуурлан, хуулийн хүрээнд, стандартыг ханган, нэр хүндтэй, үр ашигтай Монголын тэргүүлэгч нүүрсний уурхай байхад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нүүрс олборлолт, борлуулалт гэж тодорхойлжээ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий, Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Компанийн дотоод аудитаас тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй байна.

Биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр арилжаалах болсон нь өмнө мөрдөгдөж байсан бүртгэлийн баримт бичигтэй нийцэхгүй байна. Мөн үйл ажиллагаа доголдсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан банканд байршуулсан мөнгөний үлдэгдлийг эргэлтэд оруулах, холбогдох стандартын дагуу бүртгэлийн бодлогодоо тусган үнэ цэнийн бууралт тооцох тухай тусгагдаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээдийг мэргэшүүлэх шаардлагатай байна.

(Мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	718,428,614.9	373,701,070.9	-344,727,544.0
Авлага	66,403,332.2	53,227,154.8	-13,176,177.4
Бараа материал	35,908,436.6	219,319,588.1	183,411,151.5
Урьдчилж төлсөн зардал	12,958,640.7	68,825,671.9	55,867,031.2
Бусад эргэлтийн хөрөнгө	0	17,967.1	17,967.1
Үндсэн хөрөнгө	27,671,810.5	68,333,007.5	-40,661,197.0
Нийт хөрөнгө	861,370,834.9	783,424,460.3	-77,946,374.6
Богино хугацаат өр төлбөр	452,443,814.9	261,428,077.8	-191,015,737.1
Урт хугацаат өр төлбөр		12,669,551.1	12,669,551.1
Эздийн Өмч /төрийн/	48,188.7	48,188.7	0
/хувийн/	46,298.9	46,298.9	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,876,231.6	5,876,231.6	0
Хуримтлагдсан ашиг	402,956,300.8	503,356,112.2	100,399,811.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	861,370,834.9	783,424,460.3	-77,946,374.6

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 344,727,544.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудын төлөгдөөгүй татварын өр барагдуулснаас шалтгаалсан байна.

Тайлант онд авлага 13,176,177.4 мянган төгрөгөөр буурсан нь 2022, 2023 оны дутуу тайлагнасан борлуулалттай холбоотой залруулга хийгдсэнтэй холбоотой байна. Авлагын дүнд эзэн холбогдогч нь тодорхойгүй (эцсийн хэрэглэгч гэж бүртгэсэн) авлага 11 хувийг эзэлж байна.

Бараа материал үлдэгдэл өмнөх оноос 183,411,151.5 мянган төгрөгөөр өссөн нь нүүрсний олборлолт ихэссэнтэй холбоотой бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардал нь өмнөх оны үлдэгдлээс 55,867,031.2 мянган төгрөгөөр өссөн нь НАБТ тайлбайн нүүрсний үлдэгдэлд ногдох тээврийн зардлыг хойшлуулан тусгасантай холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн 17,967.1 мянган төгрөг нэмэгдсэн нь бараа материалд байсан 19,770.0 мянган төгрөгийн биологийн хөрөнгийг таваарын биологийн хөрөнгөөр салгаж бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө 40,661,197.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр барилга байгууламж 1,549,892.2 мянган, тавилга эд хогшил 223,782.0 мянган, машин тоног төхөөрөмж 2,605,090.0 мянган, тээврийн хэрэгсэл 1,503,168.6 мянган, бусад хөрөнгө 807,412.2 мянган, компьютер дагалдах хэрэгсэл 390,354.6 мянган, биет бус хөрөнгө 23,604.0 мянган, газар 426,890.0 мянган төгрөгөөр болон 2023 оны аудитын зөвлөмжийн дагуу хийгдсэн залруулгатай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр нь 12,669,551.1 мянган төгрөгөөр өссөн нь 2023 оны аудитын зөвлөмжөөр хойшлогдсон татварын өглөг 4,451,524.2 мянган төгрөгөөр, нөхөн сэргээлтийн нөөц 8,218,026.8 мянган төгрөгийн залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр 1,158,398,002.6 мянган төгрөгийн борлуулалтын орлого, 4,146,634.9 мянган төгрөгийн хүүгийн орлого, 2,616,676.4 мянган төгрөгийн бусад орлогыг бүрдүүлж, нийт 616,003,732.9 мянган төгрөг зарцуулан 549,159,581.0 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,165,163,313.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,299,646,308.8 мянган төгрөг буюу 66.5 хувиар тасарч бизнес төлөвлөгөөг хэт өндөр төлөвлөсөн нь Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ирүүлсэн чиглэлтэй холбоотой байна.

Нийт зардал 616,003,732.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,403,832,064.7 мянган төгрөг буюу 69.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь нүүрсний нийлүүлэлтийн хэмжээнээс шууд хамааралтай байна.

Тайлант онд цэвэр ашиг 412,355,270.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 673,201,115.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Зорилтод түвшний төлөвлөгөөнд бусад орлого, авлагыг тусгаж төлөвлөөгүй байгаа нь зорилтод түвшнийг бүрэн үнэлэх боломжгүй байна. Цаашид зорилтод түвшний үзүүлэлтийг тодорхойлон баталж, үзүүлэлтийг бүрэн тусган үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх шаардлагатай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгө, бараа материал, өмчийн данс, мөнгөн хөрөнгийн үнэ цэний бууралт, худалдан авах ажиллагаа, гэрээ гэрээний хэрэгжилт, анхан шатны баримтын бүрдэлд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Э.Жаргал, Ө.Болортуяа, П.Санчиргарав, туслан гүйцэтгэгч Солид Юнити аудит ХХК, чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлэн, дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдсан.

Тавантолгой ХК нь 2024 оны санхүүгийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт хөрөнгөөс 8,613,708.3 мянган төгрөгөөс 70 хувиар буюу 6,029,595.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

1. Худалдан авах барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, нийт 237,074.2 мянган төгрөгийн 51 ширхэг компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авч өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Шилэн дансны мэдээллийн системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 9-12 дугаар сард мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 36 дугаар тогтоолын дагуу "Солид Юнити Аудит" ХХК-тай гэрээ байгуулан 2022, 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн байна. Аудитаар 2022 онтой холбоотой 19,478.467.5 мянган төгрөг, 2023 онтой холбоотой 23,292,871.4 мянган төгрөгийн нийт 118 залруулга хийгдсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төрийн аудитын газраас 2023 оны санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгч нийт 198,387,311.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 6,955.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан акт, 185,186,249.6 мянган төгрөгийн 20 албан шаардлага, 13,194,106.2 мянган төгрөгийн 20 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	6,955.8	2	6,955.8	100%
Албан шаардлага	20	185,186,249.6	0	0	0
Зөвлөмж	20	13,194,106.3	0	0	0
Нийт дүн	42	198,387,311.6	2	6,955.8	0

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт дараах байдалтай байна.Үүнд:

- "Төслийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөв цөөрмийн зураг төсөл боловсруулах" ажлын гэрээг дүгнэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг төсвийг хөрөнгөд бүртгээгүй,

- Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,

- Нэг албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсэнд 1,872.0 мянган төгрөгийн нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон, 7 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл 5,083.8 мянган төгрөг илүү тооцож олгосныг буруутай албан тушаалтан хариуцаж төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосныг байгууллагаас төлж хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,

- Өмнөх аудитаар тамирчин гэсэн орон тоонд ажиллаж байгаад чөлөөлөгдсөн 3 тамирчныг дахин өөр албан тушаалд томилон ажиллуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 2024 оны санхүүгийн жилд 2 тамирчин цалинжуулсныг 2025 оны 2 дугаар сард зөрчлийг арилгасан,

- Худалдан авах барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, нийт 237,074.3 мянган төгрөгийн 51 ширхэг компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авч өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсан,

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нягтлахад шилэн дансны мэдээллийн системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 9-12 дугаар сард мэдээлээгүй байна.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар доорх асуудлуудыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Тавантолгой ХК-ийн MV-000287 тоот тусгай зөвшөөрөл бүхий уурхайн талбайд 2024 оны 12-р сарын 21-ний өдрөөс 23-ний өдрүүдэд хөндлөнгийн маркшейдер хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэж үр дүнг компанид ирүүлсэн байна. Энэхүү хэмжилтэд аудитын багийн гишүүдээс ажиглагчаар оролцоогүй бөгөөд маркшейдерийн тайланд тусгагдсан нүүрсний агуулахын үлдэгдлийн тоо хэмжээг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд тусгагдсан нүүрсний тоо хэмжээтэй тулгахад 90.3 мянган тонноор зөрүүтэй байна. Энэ нь 60 га нүүрс буулгах талбайн дэвсгэр нүүрсийг тайланд онд борлуулсныг борлуулалтын алба борлуулалтын тоо мэдээд тусган, уулын хэлтэс зарлагаар бүртгэсэн боловч санхүүгийн хэлтэс ямар үнээр орлогод авах нь тодорхойгүй, холбогдох шийдвэр гараагүйн улмаас бараа материалд орлого аваагүйтэй холбоотой байна. Иймээс дараагийн аудитаар маркшейдерийн хэмжилтэд аудитын багаас ажиглагчаар оролцох, нүүрсний үлдэгдлийг тохируулсан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2. Эрдэнэс тавантолгой ХК болон Тавантолгой ХК-ийн хооронд 2022 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээний 2.1.13-т *"Талууд нийгмийн хариуцлагын хүрээнд уурхайн нөлөөллийн бүсээс иргэд, аж ахуйн нэгжүүдийг нүүлгэн шилжүүлэх болон холбогдох дэд бүтцийн асуудлыг хамтран шийдвэрлэнэ"* гэж тусгасны дагуу 2024 оны 8-р сард Тавантолгой ХК нь шинэ суурьшлын бүсэд шилжин суурьшсан байна. Уг шилжин суурьших буюу нүүлгэн шилжүүлэх ажилтай холбоотойгоор 2019 онд хийгдсэн нөхөн төлбөр, хөрөнгийн үнэлгээ болох 9.8 тэрбум төгрөгийг Эрдэнэс тавантолгой ХК-иас тус компанид олгох хэдий ч энэхүү нөхөн төлбөр болон хөрөнгийн үнэлгээг судалж, нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, бараа материалын үнийн өсөлт, инфляцын түвшинтэй уялдуулан дахин үнэлгээ хийлгэхээр шийдвэрлэсэн ба энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг анхаарч үзэх;

3. Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/179 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулан 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс тооллогын ажлыг эхлүүлэн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр тооллогын ажлын тайлан, дүгнэлт, саналыг баталгаажуулсан байгаа бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөх, аймгийн Иргэдийн хурлын шийдвэр гараагүй байгаа тул 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тооллогын үр дүнг тусгаагүй байна. Иймээс тооллогын үр дүн, түүний хэрэгжилтийг анхаарч үзэх;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,318,985.6 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Хаан банканд байршуулсан 5602059692 тоот хадгаламжийн дансны 722,767.1 мянган төгрөгийн, Голомт банканд байршуулсан 5205129589 тоот хадгаламжийн дансны 27,905.5 мянган төгрөгийн тайлант онд хамаарах хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 *"Жинхэнэ хэрэгжилтийн"*, 5.1.4-д *"Үнэн зөв байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө"* гэсэн заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг,

2. Төрийн банканд байрших 130401861267 тоот хадгаламжийн дансны хүүгийн орлогыг тайлант онд мөнгөөр орж ирсэн үед нь нийт дүнгээр нь хүлээн зөвшөөрч бүртгэснээр тайлант оны хүүгийн орлогыг 3,548,423.1 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д *"Жинхэнэ хэрэгжилтийн"*, 5.1.4-д *"Үнэн зөв байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө"* гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

3. Авлагын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөцийг 14,873,372.1 мянган төгрөгөөр, тайлант жилийн эрсдэлийн алдагдлын нөхөлтийг 2,113,742.5 мянган төгрөгөөр дутуу тооцож бүртгэсэн байгаа нь СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийн 5.5.3-д *"Санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн бол уг санхүүгийн хэрэглүүрт хамаарах гарзын хасагдуулгыг тухайн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр тайлант үе бүрийн эцэст хэмжинэ"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д *"Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"* гэсэн заалтууд, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг;

4. Өмнөх тайлант жилд хамаарах 5,574,183.3 мянган төгрөгийн зардлуудыг тайлан жилийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д *"Жинхэнэ хэрэгжилтийн"*, 5.1.4-д *"Үнэн зөв байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө"* гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

5. Хүүгийн орлогоос суутгуулсан татварын зардал болох 339,348.2 мянган төгрөгийг ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг;

6. Ажилчдаас авах болон дараа тайлангийн авлага 45,643.2 мянган төгрөг, ХХОАТ авлага 8 мянган төгрөгийг дансны авлагаар, хойшлогдсон татварын хөрөнгө 3,325,464.6 мянган төгрөгийг бусад эргэлтийн бус хөрөнгөөр, ажилчдад өгөх өглөг, бусад богино хугацаат өглөг 82,698.0 мянган төгрөгийг дансны өглөгөөр, хойшлогдсон татварын өр 4,451,524.3 мянган төгрөг, уурхайн нөхөн сэргээлтийн нөөц ба өр төлбөр 7,220,878.3 мянган төгрөг, дансны барьцаа болон бусад богино хугацаат өр төлбөр 795,421.4 мянган төгрөг, тэтгэмжийн өглөг, ҮЭ төлбөрийн үлдэгдэл 14,033.7 мянган төгрөгийг татварын өр төлбөрт, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын өглөг 55.3 мянган төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөрөөр, газар эзэмших эрхийн 5,834,707.3 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн дансаар тус тус толилуулсан нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг;

7. Борлуулалт маркетингийн зардал 4,368,300.6 мянган төгрөгийг борлуулалтын өртөг, ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг;

8. Тайлант онд ССА/2023/004 тоот гэрээний үнээр борлуулалтын үнэлгээг тооцож АМНАТ-ыг 1,336,445.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1-д "Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан", Засгийн газрын 2016 оны 81-р тогтоолын 2-р хавсралт "Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр"-ийн 7 дугаар заалтыг;

9. Тайлант оны уурхайн нөхөн сэргээлтийн нөөцийг 997,148.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС 37 "Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй хөрөнгийн 14 а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн (хуулиар хүлээсэн эсвэл гэрээний бус) үүрэгтэй байх, б) үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай байх, в) үүргийн дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хүлээн зөвшөөрнө" гэсэн заалт, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг;

10. Тайлант оны хөрс хуулалтын зардлыг нийт дүнгээр тайлант үеийн зардлаар бүртгэж хойшлуулсан хөрс хуулалтын хөрөнгийг 10,209,499.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо (цаашид "СТОУТХ" гэнэ)-ны Тайлбар 20, "Ил уурхайн үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын зардал", Сангийн Сайдын 2016 оны 409 тоот тушаалаар баталсан "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт", хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

11. Биологийн хөрөнгийн 43,707.1 мянган төгрөгийг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөөр ангилаагүй, нас дэвшүүлж, бодит үнэ цэнээр хэмжээгүй байгаа нь НББОУС 41 Хөдөө аж ахуйн 26 "биологийн хөрөнгийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрөлтөөс, түүнчлэн уг биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ өөрчлөлтөөс бий болох олз буюу гарзыг тэдгээрийн үүссэн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана" гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг;

12. "Залаа Алтай" ХХК-д илүү төлсөн 162,673.1 мянган төгрөгийн төлбөрийг авлага үүсгэн бүртгээгүй зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

13. Тайлант он болон өмнөх тайлант онд гэрээ дүгнэсэн актаар баталгаажиж, төлбөр нь хийгдсэн, уртын тээврийн тооцоо болох 1,710,009.5 мянган төгрөгийг борлуулалтын өртөгт бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

14. НАБТ-ын талбайд тайлант оны эцэст үлдэгдэлтэй нүүрсэд ногдох 21,466,184.7 мянган төгрөгийн уртын тээврийн төлбөрийг алдаатай тооцон урьдчилгаа төлбөрт бүртгэсэн, 6,944,480.6 мянган төгрөгийн НАБТ-ын түрээсийн зардлыг өртөгт илүү бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2-д "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

15. Бусад биет бус хөрөнгийн тайлант хугацааны хорогдуулгыг 97,489.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2-д "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг;

16. Inner Mongolia Quanyide Trade компанид борлуулсан борлуулалтын орлогыг 71,365.3 мянган төгрөгөөр дутуу, урьдчилж орсон орлого, дансны авлагыг 18,712,335.7 мянган төгрөгөөр илүү, Inner Mongolia Huabin trading energy компанийн ТТОВА/2023/005 гэрээний орлогыг 4,653,442.7 мянган төгрөгөөр илүү, Xinxing Pipes (Shanghai) Metal Resources компанийн ССА/2023/004 гэрээний дансны авлага 12,361,664.6 мянган төгрөгийг урьдчилж төлсөн тооцоогоор, Urad Middel Huajia компанийн ТТОВА/2023/006 гэрээний дансны авлага, урьдчилж орсон орлогыг 27,049,433.9 мянган төгрөгөөр илүү, Inner Mongolia Huiteng Energy компанийн ТТОВА/2023/007 гэрээний урьдчилж орсон орлогыг 684,757.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2-д "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах", НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", хэмжилт ба тохиолдсон байх, батламж мэдэгдлийг;

17. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6-р сарын 17-ны өдрийн 09 дугаар тогтоолын дагуу санхүүгийн байдлын тайланд 15,591,059.3 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэлтэй тооцоо нийлсэн актаар баталгаажсан харилцагчдын үлдэгдлийг өглөгийн дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "Үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2-д "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулах", НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1 "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" гэсэн заалттай нийцээгүй, хэмжилт ба тохиолдсон байх, батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 79,494,329.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 407.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 36,477,059.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 43,017,270.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд 1 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 407.4 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааны тайланд шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээг тайлагнаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.9-д "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна", Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7.2-д "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг дээр хуулиар тогтоосон зарчим, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн боловсруулсан саналын дагуу худалдан авч байгаа эсэхэд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд 87,650.8 мянган төгрөгийн засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар" гэж заасантай нийцэхгүй байна.

3. Ерөнхий гэрээнд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хоног тутамд 0.01-0.2 хувиар алданги тооцохоор заасан ч 16 ажлын гэрээний хугацаа хэтрэлтэд 188,532.3 мянган төгрөгийн алданги тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", уг гэрээнүүдийн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

4. Тайлант онд 168,923.0 мянган төгрөгийн өртөгтэй "Төслийн барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, хөв цөөрмийн зураг төсөв"-ийг хөрөнгөд бүртгээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасантай нийцэхгүй байна.

6. Өмнөх аудитаар 1,872.0 мянган төгрөгийн цалинг шийдвэргүйгээр, 5,083.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосонд зөрчилд тогтоосон төлбөрийн актыг байгууллагаас барагдуулж, холбогдох албан тушаалтнаас авлага үүсгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

7. Ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтод шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажил үүрэг гүйцэтгэхээр заасан байхад туслах нягтлан бодогчид уг ажлыг хавсран гүйцэтгүүлж 11,736.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

8. Санхүүгийн байдлын тайланд бүртгэлтэй 658,515.4 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөг нь 2022 оноос хойш хөдөлгөөн гараагүй, өглөгийн үлдэгдлийг бөөн дүнгээр Тавантолгой ХК гэсэн харилцагчаар бүртгэсэн, харилцагчийн нэр, хэзээ төлөх нь санхүү бүртгэлд тодорхойгүй, үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

9. "Тавантолгой" ХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан "Хамтын гэрээ"-ний 6 дугаар зүйлийн 6.18-д "Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд Засгийн газраас баталсан 2019 оны 07, 2020 оны 151 дугаар тогтоолуудыг жишиг болгон компани нэг удаа буцалтгүй тусламж олгох ба үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно" гэж заасны дагуу ажилтанд тэтгэвэрт гарах үед нь тэтгэмжийг тооцон олгож байна. Мөн ажилтны тэтгэмжид зориулсан нөөц ба өр төлбөрийг санхүүгийн тайландаа тусгаж бүртгээгүй тэтгэмжийг олгох үедээ тайлант үеийн зардлаар бүртгэж байна.

Энэ нь Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 5.4-д "Салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг салбарт ажилласан жилээр үржүүлэн тооцож олгоно" гэсэн заалт болон НББОУС 19 "Ажилтны тэтгэмж"-ийн ажил эрхлэлтийн дараах тэтгэмж: Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр 63 "Аж ахуйн нэгж нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцээгүй.

10. Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дансны өглөгийн 31% буюу 5,513,412.9 мянган төгрөгийн үлдэгдэл, дансны болон бусад авлагын 49% буюу 29,641,085.8 мянган төгрөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тодотгосон төлөвлөгөөг ТУЗ-р батлуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай бүрд Компанийн дүрмийн дагуу ТУЗ-ийн гишүүдийн саналыг тусгаж, гүйцэтгэх захирлын тушаалаар баталж байх

2. Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан байхад, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 26,845,771.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварт хяналт хэрэгжүүлж, тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэх

3. Түлш, шатахуун худалдан авах ТТХК/20240102014 дугаартай 1 дүгээр багц ажлын тендерийг хуулийн хугацаанд үнэлж, шийдвэр гаргахгүй, 2023 оны №ТТХК/202301005 дугаартай "Сод монгол групп" ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний төлбөрт 1,291,065.9 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах

4. Түлш, шатахуун худалдан авах ТТХК/20240102014 дугаартай 1 дүгээр багцын гомдлыг Сангийн яам 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 03/5751 дугаар албан бичгээр тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэнийг үнэлгээний хороо 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр үнэлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг хянаж, гаргасан шийдвэрийн хуулийн хугацаанд хэрэгжүүлж ажиллах

5. Тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагаа хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний хэрэгжилт түүнд тавих хяналтыг сайжруулах

6. Тайлант хугацаанд 1,310,046.7 мянган төгрөгийн илүү цагийн ажлын хөлс тооцож олгохдоо дундаж цалин хөлснөөс тооцоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Илүү цагийн хөлсийг хэрхэн тооцож олгох талаар хамтын гэрээнд тодорхой тусгаж өгөх

7. Зарим ажлын байрны тодорхойлолт, ажилтны ажил мэргэжлийн стандарт, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт нь тодорхой бус байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдийн ажлын байрны тодорхойлолтод ажлыг чиг үүрэг, ажилтны ажил мэргэжлийн стандарт, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаж шинэчлэх

8. Урьдчилж гарсан зардал, тооцооны дансны үлдэгдэлд залруулга хийхдээ харилцагчийн нэр, урьдчилгааны дансыг зөрүүтэй бүртгэсэнтэй холбоотой 1802-00-00-00

тоот дансны үлдэгдэл гүйлгээ балансад 472,371.8 мянган төгрөгөөр сөрөг утгатай илэрхийлэгдсэн.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программд харилцагчийн үлдэгдлийг зөрүүлж бүртгэсэн гүйлгээг залруулж, харилцагчийн үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

9. Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 375 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

10. Уурхайн харуул хамгаалалтын 454,521.8 мянган төгрөгийн зардлыг олборлосон нүүрсний өртөг хуримтлуулан бүртгээгүй ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Олборлосон нүүрсний өртгийг хуваарилах арга зүй боловсруулан, өртгийг бүрдүүлэх зардал болон зардлыг хуваарилах суурь үзүүлэлтийг оновчтой болгож мөрдөх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

11. Компанийн дүрэмд 52,665.2 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй гэж тусгасан байгаа ч санхүүгийн байдлын тайланд 94,487.6 мянган төгрөгийн, компанийн гэрчилгээнд 94,480.0 мянган төгрөгийн өмчтэй буюу хувь нийлүүлсэн хөрөнгөтэй гэж тусгасан байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгө компанийн дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгийн хооронд 41,822.4 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг холбогдох шийдвэрийн дагуу санхүү байдлын тайланд зөв дүнгээр тусгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

12. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 10,623,366.3 мянган төгрөг буюу 2.8% нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан Үндэсний хөрөнгө оруулалтын банканд, 1,978,304.8 мянган төгрөг буюу 0.6% нь Чингис хаан банканд байршсан хөдөлгөөн гараагүй, компани үйл ажиллагаандаа зарцуулах эрх хязгаарлагдмал байгаа ч үнэ цэнийн бууралт тооцоогүй, НБББББ-тээ хэрхэн бүртгэх талаар тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийг зөв удирдаагүй, эрсдэлийг оновчтой хянаагүйгээс үйл ажиллагаа доголдсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан банканд байршуулсан мөнгөний үлдэгдлийг эргэлтэд оруулах, холбогдох стандартын дагуу бүртгэлийн бодлогодоо тусган үнэ цэнийн бууралт тооцох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
										Залруулсан		Залруулаагүй	
										Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТУЗ-ын гишүүдэд 1,922,000 төгрөгийн говийн нэмэгдэл, унааны нөхөн олговрыг бүртгэлд буруу тусгасан	1	1,922.0			1	1,922.0	1	1,922.0	-	-	-	-
2	Албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг бүртгэлд буруу тусгасан.	1	624.0			1	624.0	1	624.0				
3	Хаан банкны 5602059692 тоот хадгаламжийн дансны хүүгийн орлогыг дутуу бүртгэсэн	1	722,767.1	1	722,767.1								
4	Голомт банкны 5205129589 тоот хадгаламжийн дансны хүүгийн орлогыг дутуу бүртгэсэн	1	27,905.4	1	27,905.4								
5	Төрийн банкны 130401861267 тоот хадгаламжийн дансны 2023 онд хамаарах хүүгийн орлогыг залруулав	1	3,548,423.1			1	3,548,423.1						
6	Тайлант хугацааны зардлаар өмнөх тайлант жилийн зардлыг бүртгэсэн	1	5,574,183.3			1	5,574,183.3						
7	Хүүгийн орлогоос суутгуулсан татварыг ерөнхий удирдлагын зардлаар ангилал зөрүүлэн бүртгэсэн	1	339,348.2			1	339,348.2						
8	Борлуулалт марктенгийн зардлыг ББӨ, Ерөнхий удирдлагаар толилуулсан.	1	4,368,300.6			1	4,368,300.6						
9	Тайлант оны АМНАТ-ыг дутуу тооцож тайлагнасан	1	1,336,445.3	1	1,336,445.3								
10	Уурхайн нөхөн сэргээлтийн нөөцийг НББОУС 37-ын дагуу тооцон бүртгээгүй.	1	997,157.5	1	997,157.5								
11	СТОУС 6-ын дагуу хойшлуулж тооцох хөрс хуулалтын хөрөнгийг бүртгээгүй	1	10,209,499.5	1	10,209,499.5								
12	Биологийн хөрөнгийг эргэлтийн болон эргэлтийн бусаар ангилан толилуулаагүй, бараа, материалын дансанд толилуулсан-бодит үнэ цэнээр хэмжээгүй	1	43,707.1	1	43,707.1								
13	Залаа Алтай ХХК-д илүү төлсөн төлбөрийг авлага үүсгэн бүртгээгүй	1	162,673.1	1	162,673.1								

(мянган төгрөгөөр)

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

14	Тайлант он болон өмнөх тайлант онд гэрээ дүгнэсэн актаар баталгаажиж төлбөр нь хийгдсэн уртын тээврийн тооцоог ББӨ дансанд бүртгээгүй	1	1,710,009.5	1	1,710,009.5								
15	НАБТ-ын талбайд үлдэгдэлтэй нүүрсэд ногдох уртын тээврийн төлбөрийг алдаатай тооцон бүртгэсэн	1			21,466,184.7	1	21,466,184.7						
16	Бусад биет бус хөрөнгийн тайлант хугацааны хорогдуулалтыг дутуу тайлагнасан	1			97,489.2	1	97,489.2						
17	Inner Mongolia Huifeng Energy Co.Ltd ТТ0А/2023/007 орлого, авлага, урьдчилгааг тохируулав	1			684,757.63	1	684,757.63						
18	ТУЗ тогтоолын дагуу буцаан төлөхөөр шийдвэрлэсэн тооцоо нийлсэн дүнтэй УОО өглөгөөр бүртгэв	1			15,591,059.3	1	15,591,059.3						
19	Газар эзэмших эрхийг биет бус хөрөнгөөр бус үндсэн хөрөнгөөр толилуулсан	1			5,834,707.3	1	5,834,707.3						
20	Авлагын дансанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал, нөөцийг тооцон бүртгээгүй	1			14,873,372.1	1	14,873,372.1						
21	ХХОАТ-ын авлагыг дансны авлагаар толилуулсан	1			8.0	1	8.0						
22	Санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон татварын хөрөнгийг бусад эргэлтийн бус хөрөнгөөр толилуулсан	1			3,325,464.6	1	3,325,464.6						
23	Ажилчдад өгөх өлөг, бусад өглөгийг дансны өглөгөөр толилуулсан	1			82,698.0	1	82,698.0						
24	Татварын өр төлбөрийн дансанд хойшлогдсон татварын өр төлбөрийг толилуулсан	1			4,451,524.3	1	4,451,524.3						
25	Татварын өр төлбөрийн дансанд уурхайн нөхөн сэргээлтийн нөөц ба өр төлбөрийг толилуулсан.	1			7,220,878.3	1	7,220,878.3						
26	Татварын өр төлбөрийн дансанд барьцаа болон бусад богино хугацаат өр төлбөрийг толилуулсан	1			795,421.4	1	795,421.4						
27	Суутгачийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын өглөгийг бусад богино хугацаат өр төлбөрөөр толилуулсан	1			55.3	1	55.3						
28	Бусад богино хугацаат өр төлбөрөөр толилуулах лист, ҮЗ төлбөрийн үлдэгдлийг татварын өр төлбөрт толилуулсан	1			14,033.7	1	14,033.7						
29	Inner Mongolia Huabin trading energy ТТ0А/2023/005 компанийн орлого, урьдчилгаа, авлагын дансыг залруулав	1			4,653,442.7	1	4,653,442.7						

Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

30	Urad Middel Huajia TTOA/2023/006 авлаг, урьдчилгааг хааж бүртгэсэн	1	27,049,433.9		1	27,049,433.9			
31	XinXing Гадаадын худалдан авагчаас авах борлуулалтын авлагыг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн. (3,614,257.6\$)	1	12,361,664.6		1	12,361,664.6			
32	Борлуулаагүй нүүрсэд ногдох НАБТ-ын түрээсийн зардлын өртөлт илүү дүнгээр бүртгэсэн	1	6,944,480.6		1	6,944,480.6			
33	Ажилчдаас авах авлага, дараа тайлангийн авлагыг дансны авлагаар толилуулсан	1	45,643.2		1	45,643.2			
34	Inner Mongolia Quanyide Trade компанийн орлого, урьдчилгаа, авлагын дансыг залруулав	1	18,783,701.1		1	18,783,701.1			
	Нийт дүн	34	173,318,985.6	9	15,307,653.8	25	158,011,331.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Үүнээс												(мянган төгрөгөөр)	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	"Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө"-г ТУЗ батлуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй	1	0					1	0						
2	Худалдан авах ажиллагааны тайланд шууд гэрээ байгуулсан бараа, ажил, үйлчилгээг тайлагнаагүй	1	0			1	0								
3	Тайлант онд 87,650,875 төгрөгийн засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалт хийсэн	1	87,650.8			1	87,650.8								
4	"Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/-ын нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зарласан байхад, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 26,845,771,018 төгрөг шилжүүлсэн	1	26,845,771.0					1	26,845,771.0						
5	Түлш, шатахуун худалдан авах ТТХК/20240102014 дугаартай 1 дүгээр багц ажлын тендерийг хуулийн хугацаанд үнэлж, шийдвэр гаргалгүй, 2023 оны №ТТХК/202301005	1	1,291,065.9					1	1,291,065.9						

